**2007 ОНЫ 3 ДУГААР САР**

# АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий систем (ХЕС) хөтөлбөр

Америкийн аж үйлдвэрийн салбарууд болон хэрэглэгчдийн сонголтыг өргөжүүлэх замаар хөгжиж буй орнуудад эдийн засгийн таатай боломж олгох зорилгоор АНУ-ын Конгрессоос тус улсын ХЕС-ийг хоёр талын өргөн дэмжлэгтэйгээр 1974 онд нэвтрүүлсэн. АНУ-ын ХЕС хөтөлбөр нь нэр дурдагдсан ашиг хүртэгч хөгжиж буй 134 орон (АХХБО) ба нутаг дэвсгэрээс импортлох 3,400 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татваргүйгээр тус улсын хилээр оруулах хөнгөлөлттэй нөхцөл олгодог. Нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орон (НБХХБАХО)-уудаас импортоор оруулж болох өөр 1450 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг 1996 оноос эхлэж дээрх хөнгөлөлтөд нэмж хамруулсан. Одоогоор ХЕС-ээс ашиг тус хүртэж буй нэн буурай хөгжилтэй нийт 43 улс орон байна. ХЕС-ийн дагуу АНУ-ын хилээр нэвтэрсэн бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээ 2006 онд 32,6 тэрбум америк долларт хүрснээр 2005 оныхтой харьцуулбал даруй 22 хувиар өсчээ.

(НБХХБАХО) Нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орон
(АХХБО) Ашиг хүртэгч хөгжиж буй орон

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүний нэгдсэн жагсаалтад аж үйлдвэрийн болон хагас аж үйлдвэрийн ихэнх нэр төрлийн гаалийн татвартай бараа бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуй, загас агнуурын зарим нэр төрлийн бүтээгдэхүүнээс гадна аж үйлдвэрийн үндсэн бараа тус тус багтдаг. 2006 онд АНУ-ын импортын голлох бараа бүтээгдэхүүний тоонд нефтийн бүтээгдэхүүн, алтаар хийсэн эрдэнийн чулуун гоёл чимэглэлийн зүйлс, хөнгөн цагааны хайлшан бүтээгдэхүүнүүд, катодын баяжуулсан зэс, метанол болон мөнгөөр урласан эрдэнийн чулуун ноёл чимэглэлийн хэрэгсэл орж байв. 2006 онд Монгол Улсаас АНУ руу импортолсон бараа бүтээгдэхүүнд вольфрамын баяжмал, хуванцар өлгүүр, гэр ахуйн болон ариун цэврийн хуванцар хэрэгсэл, бөс даавуун бүтээгдэхүүн буюу бэлэн хувцасны хуванцар эд зүйлс болон амьтны арьсаар хийсэн малгай багтсан.

ХЕС-ийн дүрмээр зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг ХЕС-д хамааруулдаггүй бөгөөд ийм төрлийн бүтээгдэхүүнд хөвөн даавуу, ноос, хүний гараар бүтсэн мяндас, түүнчлэн бусад төрлийн ургамлын гаралтай мяндас (маалинга ба хятад халгай); цаг; зарим нэр төрлийн гутал болон гар цүнх; ачааны зориулалттай цүнх, сав; торгоноос өөр төрлийн даавуугаар хийсэн хавтгай эдлэлүүд; ажлын бээлий; мөн ширээр урласан бусад нэр төрлийн эдлэлүүд тус тус багттдаг.

**Импортын бараа бүтээгдэхүүн ХЕС-д хэрхэн хамрагдах вэ?**
ХЕС-д хамаарах импортын бараа бүтээгдэхүүн нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой:

- ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүний жагсаалтад байх ёстой.
- Уг бараа бүтэгдэхүүн нь нэр дурдсан ашиг хүртэгч хөгжиж буй орон (АХХБО)-оос АНУ руу шууд импортлогдох, эсвэл өөр улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхдөө битүүмжилсэн саванд хийсэн байх ёстой.

- Уг бараа бүтэгдэхүүн нь АХХБО-д өсгөсөн, ургуулсан эсвэл үйлдвэрлэсэн бараа байх ёстой.
- Тухайн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигладаг, түүний орцонд ордог зүйлийг ХЕС-ээс ашиг тус хүртэгч улсаас өөр орноос импортолж байгаа бол ашиг хүртэгч оронд үйлдвэрлэсэн бараа материалын өртөг ба үнэлгээн дээр боловсруулалтын шууд зардлыг нэмсэн дүн нь тухайн нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг АНУ руу экспортолж буй үеийн үнийн 35-аас доошгүй хувьтай тэнцүү байх ёстой. Импортлогдсон бараа бүтээгдэхүүний үнэлгээ нь тэдгээр бараа хожим нь зөвхөн ХЕС-д хамрагдаж, экспортлогдох бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашиглагдах шинэ буюу өөр төрлийн бүрдэл материал болж "үлэмж хэмжээгээр өөрчлөгдсөн" нөхцөлд л 35%-ийн нэмэгдсэн өртгийн шаардлагад нийцсэнд тооцогдоно. "үлэмж хэмжээгээр өөрчлөгдсөн" гэдэг нь тухайн төрлийн бүрдэл материалыг АНУ-ын Гаалийн албанаас өөр нэр төрлийн эд зүйл болсон хэмээн үзэж ангилалд оруулсныг ойлгоно. (Хавсралт С-н үзнэ үү)
- Бараа экспортолж буй буюу импортолж буй этгээд нь АНУЗТХ-ийн дугаарын өмнө "A" , "A+," эсвэл "A*" тэмдэг тавьж ХЕС-ийн дагуух гаалийн татвараас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргах ёстой бөгөөд энэ нь тээвэрлэлтийн холбогдох баримт бичигт импортолж буй бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох юм. (Хавсралт В-г үзнэ үү)

**Хэрэгцээний хязгаарлалтыг хуульд заасны дагуу ногдуулах**

Хэрэгцээний хязгаар (ХХ) нь тухайн нэр төрлийн бүтээгдэхүүн болон ХЕС-г хүртэгч улсад ХЕС-ээс ашиг тус хүртэх боломжид тавьж буй хязгаарлалт юм. Тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ хэрэгцээний хязгаараас давсан бөгөөд түүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг ёсоор болгоогүй бол аль нэг хүртэгч орон нь ХЕС-д хамрагдах боломжоо шууд алдана. Гэсэн хэдий ч ХЕС-г хүртэгч нэн буурай хөгжиж буй улс орнууд (LDBDCs) нь бүх төрлийн ХХ-аас шууд чөлөөлөгддөг.

**Бүс нутгийн холбоодод гишүүнээр элссэн ХЕС-ээс ашиг хүртэгч улсуудын оруулсан бараа бүтээгдэхүүнийг хүлээн авна**

ХЕС-ийн хөтөлбөр нь бүс нутгийн холбоодод гишүүнээр элссэн ашиг хүртэгч хөгжиж буй орнуудад зориулсан тусгай зохицуулалттай юм. ХЕС-ийн гарал үүслийн шаардлагын үүднээс бүс нутгийн холбоог нэг улс гэж авч үздэг. Тухайн холбооны гишүүн, ХЕС-д хамрагдах боломжтой хоёр ба түүнээс дээш тооны улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн нь дээрх орнууд хамтдаа гарал үүслийн шаардлагыг биелүүлж байгаа нөхцөлд л гаалийн татварын хөнгөлөлтөд хамрагдаж болно. Бүс нутгийн аль нэг холбооны гишүүн нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орон мөн тухайн холбооны нэн буурай хөгжилтэй бус хөгжиж буй ашиг хүртэгч оронтой хамтран тэдгээр орнуудад зориулж эрх зүйн баримт бичигт тусгайлан заасан 1400 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний нэгийг үйлдвэрлэж болох юм. Тухайн нэр төрлийн бараа бүтээгдэхүүн нь нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орноос АНУ руу шууд тээвэрлэгдэн очиж байгаа хугацаандаа ХЕС-ийн дагуу хөнгөлөлтөд хамрагдана.

**Гар аргаар үйлдвэрлэгдсэн, ХЕС-д хамрагдах бөс даавуун бүтээгдэхүүнд холбогдох тусгай зохицуулалт**

ХЕС-ээс ашиг хүртэгч арван гурван улс "зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гар аргаар үйлдвэрлэгдсэн гэдгийг баталгаажуулж гэрчилгээжүүлэх асуудлаар" Америкийн Нэгдсэн Улстай тусгай зохицуулалт хийсэн учраас тэдгээр бараа нь ХЕС-ийн дагуу гаалийн татвараас чөлөөлөгддөг байна. Тэрхүү гэрээнд заасны дагуу ашиг хүртэгч улсаас баталгаажуулсан гараар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн хананд өлгөх зориулалттай эд зүйлс; гараар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн дэрний уут; гараар нэхсэн зарим нэр төрлийн шалан дээр дэвсэх зориулалттай эдлэлийг гаалийн татвараас чөлөөлөх бололцоог АНУ-д олгодог. Чөлөөлсөн татварын хувь хэмжээ нь 3,8-аас 4.3-ын хооронд хэлбэлздэг.

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?**
ХЕС-ийн талаар нэмэлт мэдээлэл, түүн дотроо зааварчилгааны ном болон тус системд хамрагдах бараа бүтээгдэхүүний нэр төрлийг мэдэх хүсэлтэй байгаа бол http://www.ustr.gov/Trade_Development/Preference_Programs/GSP/Section_Index.html гэсэн вэб сайт руу ороорой.
Түүнчлэн 202-395-6971 дугаарын утсаар бидэнтэй холбогдож болохоос гадна цахим шуудангийн contactustr@ustr.eop.gov хаягаар харьцаж болно.

## Монгол Улсын эдийн засгийн тойм

### Ерөнхий байдал

Монгол Улсын эдийн засаг нь он удаан жилийн өмнөөс мал аж ахуй болон газар тариаланд үндэслэж ирсэн уламжлалтай юм. Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн нь улаан буудай, арвай, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал, хонь, ямаа, үхэр, тэмээ ба адуу.

Тус улс нь мөн байгалийн эрдэс баялгийн асар их нөөцтэй юм. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн ихээхэн хэсгийг зэс, нүүрс, молибден, цагаан тугалга, вольфрам болон алт эзэлдэг. Аж үйлдвэрийн гол салбаруудын тоонд барилга ба барилгын материал; уул уурхай (нүүрс, зэс, молибден, хайлуур жонш, цагаан тугалга, вольфрам болон алт); газрын тос; хүнсний бүтээгдэхүүн, ундаа; малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, ямааны ноолуур болон байгалийн гаралтай мяндасны үйлдвэрлэл тус тус багтана.

2005 онд Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүнд зэс, бөс даавуу, малын түүхий эд, ноолуур, ноос, малын арьс шир, хайлуур жонш болон бусад төрлийн өнгөт металл хамаарч байв. Тухайн онд экспортын гол зах зээл нь Хятад (48.1 хувь), Америкийн Нэгдсэн Улс 14.2 хувь), Канад (11.6 хувь), Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (8.3 хувь) ба Өмнөд Солонгос (6.2 хувь) байжээ.

2005 онд Монгол Улсын импортоор авсан гол нэрийн бараа бүтээгдэхүүнд машин механизм ба тоног төхөөрөмж, түлш шатахуун, суудлын машин, хүнсний бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн хэрэглээний бараа, химийн бүтээгдэхүүн, барилгын материал, элсэн чихэр

ба цай тус тус багтаж байв. Тухайн жилд хүлээж авсан импортын бараа бүтээгдэхүүний голлох нийлүүлэгчид нь Оросын Холбооны Улс (34.5 хувь), Хятад (27.4 хувь), Япон (7.1 хувь) болон Өмнөд Солонгос (5.3 хувь) байжээ.

<u>ХЕС</u>

Монгол Улс нь 1999 оноос эхэлж ХЕС-ийн хөтөлбөрт хамрагдаж ашиг хүртэгч хөгжиж буй орнуудын тоонд орсон юм. Тус улсаас ХЕС-ийн дагуу АНУ-ын авч буй импортын бараа бүтээгдэхүүний хэмжээ жил ирэх тутам өсч буй. Монгол Улсаас ХЕС-ийн дагуу АНУ-ын хүлээн авсан импортын хэмжээ 2005 онд 161915 америк доллар байсан бол 2006 онд 530116 долларт хүрч 227,4 хувиар нэмэгдсэн байна. ХЕС-ийн дагуу Монгол Улсаас авсан импортын хэмжээ нь АНУ-ын зүгээс тус улсаас хүлээн авсан нийт импортын 0,5 хувийг эзэлж байгаа. Монгол Улс нь мөн ХЕС-ийн бусад хөтөлбөрүүд, тэр дундаа Европын Холбоо (ЕХ), Япон болон Шинэ Зеландын хөнгөлөлтийн системд хамрагддаг.

**<u>ХЕС-ийн дагуу гаалийн татвараас чөлөөлөгдөх Монгол Улсын боломжийг нэмэгдүүлэх талаар</u>**

- Монгол Улсаас АНУ руу орж ирж буй ХЕС-д хамрагдах экспортын бараа бүтээгдэхүүний хувьд шаардлагагүй үед гаалийн татвар төлөхгүй байх үүднээс ХЕС-д хамаарах бүх нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн бүрдүүлэлт хийж оруулахдаа АНУ-ын Зохицуулалттай тарифийн хуваарь (АНУЗТХ)-ийн дагуу баримт бичиг дээр нь “A” эсвэл “A*” тэмдгийг тавьсан эсэхийг шалгах. (Хавсралт B-г үзнэ үү)
- ХЕС-д хамрагдах боломжтой бөс даавуун болон нэхмэл бүтээгдэхүүний экспортлох боломжийг эрж хайж, нэмэгдүүлэх.
- Бараа бүтээгдэхүүнийг АНУ руу экспортолж, улмаар тус улсын гаалийн татвараас чөлөөлөх хөтөлбөрт хамруулах боломжтой эсэхийг тогтоох зорилгоор Монгол Улс нь бусад улсуудын ХЕС-д хамрагдсаны дагуу тэдгээр улс руу ямар нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг экспортолж буйг олж тогтоох (жишээ нь, тээвэрлэлттэй холбоотой ойролцоо хүндрэл гардаг Европын Холбоо болон Япон).
- ХЕС-д хамрагдах боломжтой ашигт малтмалыг олж тогтоох.
- Дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний талаар судалгаа шинжилгээ хийсний үндсэн дээр чухам аль нэр төрөл нь ХЕС-д хамрагдаж болохыг тодорхойлох.
- Зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гар аргаар үйлдвэрлэгдсэн гэдгийг баталгаажуулж гэрчилгээжүүлэх асуудлаар Америкийн Нэгдсэн Улстай тусгай хэлэлцээр байгуулснаар гаалийн татвар ногдуулах учиртай хивс, ханын аравч болон дэрний уутыг татвараас чөлөөлж хилээр нэвтрүүлэх.

**<u>ХЕС-ийн хөтөлбөрийн дагуу Монгол Улсаас АНУ-ын авсан импорт</u>**

- Монгол Улсаас ХЕС-ийн дагуу АНУ-ын хүлээн авсан импортын хэмжээ 2006 онд 530116 доллар хүрснээр тус улсаас АНУ-ын хүлээн авсан нийт импортын дөнгөж 0,6 хувьтай тэнцэж байгаа юм. 2005 оных 161915 америк доллар буюу Монгол Улсаас АНУ руу импортолсон бараа бүтээгдэхүүний нийт хэмжээний 0,1 хувь байсантай харьцуулбал энэ нь хоёроос илүү дахин өссөн дүн.

- ХЕС-д хамрагдсан байдлаар нь авч үзвэл АНУ-ын хүлээн авсан импортын хэмжээ 2005 онд 374587 америк доллар байсан бол 2006 онд 912435 долларт хүрч, 143,6 хувиар нэмэгдсэн байна.
- Монгол Улсын ХЕС-ийн ашиглалтын түвшин 2006 онд 58,1 хувьд хүрснээр өмнөх жилийнх нь үзүүлэлт болох 43,2 хувьтай харьцуулбал ихээхэн өссөн тоо боловч ХЕС-ээс ашиг хүртэгч орнуудын дэлхийн хэмжээний түвшин буюу 71 хувиас доогуур амжилт болж байна.
- Монгол Улсаас ХЕС-ийн дагуу АНУ-ын импортолсон гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний америк доллараар илэрхийлсэн үнэлгээгээр 2006 оны хувьд вольфрамын баяжмал, хуванцар өлгүүр, гэр ахуйн болон бөс даавуун бүтээгдэхүүний тоног хэрэгсэл тэргүүлсэн. (Импортын голлох бараа бүтээгдэхүүн болон ХЕС-ийн дагуух импортын бараа бүтээгдэхүүний бүрэн хэмжээний жагсаалтыг дор бичсэнээс үзнэ үү.)

**Импортын бүх нэр төрлийн бүтээгдэхүүнүүд: АНУТУС-ийн дугаар болон гаалийн үнэлгээний дагуух гаалийн үнэлгээ**
**Монгол Улсын ХЕС-д хамрагдсан байдлын дагуу**

**АНУ-ын хэрэглээний импортын жил тутмын мэдээлэл**

| АНУТУС-ийн дугаар | Улсын нэр | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2005 – 2006 оны өөрчлөлт, хувиар |
|---|---|---|---|---|---|---|
| | | *Бодит доллараар* | | | | |
| 26110060 Вольфрамын баяжмал | Монгол Улс | 45,870 | 85,406 | 75,883 | 367,176 | 383.9% |
| 39239000 Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, эсвэл баглаж боох зориулалттай хуванцар материал, несой байдлаар | Монгол Улс | 41,566 | 35,989 | 77,632 | 145,614 | 87.6% |
| 39249055 Гэр ахуйн болон ариун цэврийн өрөөний хуванцар эдлэлүүд, несой байдлаар | Монгол Улс | 39,432 | 0 | 0 | 14,173 | Мэдээлэл байхгүй |
| 39262090 Бөс даавуун материал, хувцасны хуванцар | Монгол Улс | 0 | 0 | 0 | 2,804 | Мэдээлэл байхгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| тоноглол, несой байдлаар | | | | | | |
| 39269098<br>Хуванцраар хийсэн бусад нэр төрлийн эдлэл, несой байдлаар | Монгол Улс | 2,786 | 0 | 0 | 0 | Мэдээлэл байхгүй |
| 42033000<br>Горхитой, эсвэл горхигүй, ширээр буюу дуриамал арьсаар хийсэн бүс, бүсэн цүнх | Монгол Улс | 0 | 20,370 | 0 | 0 | Мэдээлэл байхгүй |
| 65069200<br>Амьтны арьсаар хийсэн, хуниастай, эсвэл хуниасгүй, эмжээрлэсэн, эсвэл үгүй байдалтай малгай, несой байдлаар | Монгол Улс | 0 | 0 | 0 | 349 | Мэдээлэл байхгүй |
| 85167100<br>Цахилгаанаар халдаг, кофе буюу цай буцалгагч, гэр ахуйн зориулалттай | Монгол Улс | 0 | 0 | 8,400 | 0 | -100.0% |
| **Нийт** | | **129,654** | **141,765** | **161,915** | **530,116** | **227.4%** |

Эх сурвалж: Энэ хэсэг дэх мэдээллийг АНУ-ын Худалдааны Департамент болон АНУ-ын Олон улсын худалдааны комиссийн тариф, худалдаатай холбоотой мэдээллийн сангаас түүвэрлэн авав.

**Ашиг тус хүртээгүй боловч ХЕС-д хамрагдах боломжтой, Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний нэр төрөл:**

Монгол Улсаас АНУ руу гаргасан, ойролцоогоор 382319 америк долларын үнэ бүхий импортын бараа бүтээгдэхүүнийг ХЕС-д хамруулж болох байсан боловч 2006 онд тийм хүсэлтийг тус хөтөлбөрийн дагуу гаргаж өгөөгүй байна. 154000 гаруй долларын үнэ бүхий хуванцар эдлэлийг импортлохдоо адил нэр төрлийн бараа ХЕС-д хамрагдсан ангиллын дагуу гаалийн татвар төлж нэвтрүүлсэн бөгөөд эдгээр хуванцар эдлэлийн хувьд ХЕС-ийн ашиглалтын түвшин дөнгөж 21,6 хувь байна. Бусад нэр төрлийн бараа бүтээгдэхүүний тухайд ашиглалтын хувь хэмжээ нь тэгтэй тэнцүү байсан нь ХЕС-ийн ашиг тусыг хүртэх ихээхэн боломжийг алдсан гэсэн үг юм.

Бараа бүтээгдэхүүнийг ХЕС-д хамруулж, гаалийн татвараас чөлөөлүүлэхгүй байгаагийн нэг шалтгаан бол тухайн импорт нь ХЕС-ийн дагуух гарал үүслийн шаардлагыг хангаж биелүүлдэггүйтэй холбоотой. Импорт зохих шаардлагыг хангаж байгаа гэж үзвэл төлөх

шаардлагагүй байсан гаалийн татварын хувь хэмжээ нь тогтмол цахилгааны хувьсгагч (ТУС-ийн дугаар нь 85044095)-ийн хувьд 1,5 хувь, харин үндэсний далбаа (ТУС-ийн дугаар нь 63079098)-ны тухайд 7 хувьтай тус тус тэнцүү байжээ.

Сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол Улсаас ХЕС-д хамруулан импортлох боломжтой байсан боловч тийнхүү хүсэлтээ тавьж шийдвэрлүүлээгүй бараа бүтээгдэхүүний нэр төрлүүдийг дараахь хүснэгтээс харна уу.

| ТУС8 | Барааны тодорхойлолт | Хөтөлбөр | 2004 он | 2005 он | 2006 он | Хамгийн их давуу эрх хүртдэг орны төлөх хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| 12099180 | Хүнсний ногооны үр, тариалах зориулалттай, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 113,139 | 0 | 0 | 1.5 цент/кг |
| 39239000 | Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, эсвэл баглаж боох зориулалттай хуванцар материал, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 227,534 | 156,315 | 143,972 | 3% |
| 39261000 | Ажлын өрөөний, эсвэл сургуулийн хэрэгцээний эд зүйлс, хуванцраар хийсэн | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 22,511 | 0 | 0 | 5.3% |
| 39262090 | Бөс даавуун материал, хувцасны хуванцар тоноглол, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 32,468 | 0 | 10,158 | 5% |
| 39269098 | Хуванцраар хийсэн бусад нэр төрлийн эдлэл, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 10,060 | 0 | 0 | 5.3% |
| 40169960 | Хатуу резинээс бусад нэр төрлийн, торлог бус, хүхэржүүлсэн нийлэг резинэн эдлэл | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 268 | 0 | 0 | 2.5% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 42010060 | Ямар ч материалаар хийсэн байж болох, амьтдын тоног хэрэгсэл болон тусгай хэрэглэлүүд (цулбуур, жолоо, өвдөгний зөөлөвч, хошуувч, эмээлний материал, цүнх болон бусад эдлэл), несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 300 | 0 | 2.8% |
| 43031000 | Бөс даавуун материал, хувцасны амьтны арьсаар хийсэн тоноглол | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 270 | 0 | 0 | 4% |
| 44190080 | Хоол, ундны болон гал тогооны өрөөний модон хэрэгсэл, халбага, сэрээнээс бусад | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 2,800 | 0 | 3.2% |
| 44201000 | Модоор урласан жижиг уран баримал, модоор хийсэн гоёл чимэглэлийн бусад хэрэглэлүүд | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 35,270 | 0 | 0 | 3.2% |
| 51031000 | Ноос буюу амьтны сайн чанарын үсний сэв | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 45,604 | 2.6 цент/кг |
| 62044910 | Ердийн зүүгээр, эсвэл дэгээ зүүгээр нэхээгүй, жингийнх нь 70 буюу түүнээс дээшхи хувь нь торго, эсвэл хаягдал торгоноос бүтсэн эмэгтэйчүүдийн буюу охидын хувцас | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 320 | 6.9% |
| 63079098 | Бөс даавуугаар хийсэн үндэсний далбаа буюу бусад нэр төрлийн эдлэлүүд, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 1,195 | 2,473 | 7% |
| 67021040 | Хиймэл цэцэг/навч/жимс, жимсгэнэ; хиймэл цэцгэн эдлэл гэх мэт; бүгд хуванцраар хийгдсэн, нугалах/цавуугаар наах/эсвэл эдгээртэй ойролцоо аргаар угсарч, нийлүүлээгүй байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 16,070 | 0 | 3.4% |
| 70200060 | Өөр нэр төрөлтэй давхцахааргүй | Хөтөлбөрт | 0 | 0 | 2,500 | 5% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | буюу аль нэг нэр төрлийн бараа бүтээгдэхүүний бүрдэл хэсэг болохооргүй шилэн эдлэлүүд | хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | | | | |
| 71131150 | Мөнгөөр урласан гоёл чимэглэлийн зүйлс болон тэдгээрийн бүрдэл хэсгүүд, несои хэлбэрийн, 12 ширхэг нь буюу бүрдэл хэсэг нь 18 америк доллараас дээш үнэтэй | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 8,975 | 0 | 5% |
| 73239990 | Төмөр (цутгамал)/ган (цагаан тугалгаар өнгөлөөгүй буюу зэвэрдэггүй бус), ширээний, гал тогооны (хоол бэлдэхээс бусад), эсвэл гэр ахуйн хэрэгцээний хэрэгслүүд, тэдгээрийн бүрдэл хэсгүүд, бүрээгүй/шармал бус, үнэт чулуу бүхий | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 2,815 | 0 | 0 | 3.4% |
| 79070010 | Гэр ахуйн, ширээний болон гал тогооны зориулалттай, цинкээр хийсэн эдлэлүүд; ариун цэврийн өрөөний, эсвэл эрүүл ахуйн зориулалттай, цинкээр урласан эдлэл; дээр дурдсан бүх эдлэлүүдийн цинкэн сэлбэг, бүрдэл хэсгүүд | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 4,056 | 0 | 0 | 3% |
| 84828000 | Бөөрөнхий, эсвэл эргэлдэгч холхивч, несой байдлаар, усгарсан хэлбэртэй бөөрөнхий/эсвэл эргэлдэгч холхивчийг оролцуулан | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 9,862 | 5.8% |
| 85044095 | Тогтмол цахилгаан хувьсгагч (жишээ нь, шулуутгагч гэх мэт), несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 14,990 | 1.5% |
| 85167100 | Цахилгаанаар халдаг, кофе буюу цай буцалгагч, гэр ахуйн зориулалттай | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 4,450 | 3.7% |
| 85439088 | Цахилгаан машин, багаж хэрэгслийн сэлбэг (давталтын хэвлэмэл хэрэгслээс бусад), хамааралгүйгээр ажиллах боломжтой, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 34,900 | 2.6% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 87082950 | 8702-8705 дугаарын тээврийн хэрэгслийн их биеийн сэлбэг, хэрэгсэл, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 16,668 | 2.5% |
| 90289000 | Үйлдвэрлэлийн, эсвэл нийлүүлэлтийн үед хий, шингэн буюу цахилгааныг хэмжих багаж | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 75,629 | 3.2% |
| 90308900 | Цахилгааны хүчдэл, эсвэл ионжуулагч цацрагийг хэмжих, илрүүлэх буюу шалгах багаж хэрэгсэл, несой байдлаар, бичлэг хийх хэрэгсэлгүйгээр | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 18,283 | 1.7% |
| 94049020 | Хөвөнгөөс бусад төрлийн даавуугаар хийсэн дэр, зөөлөвч болон эдгээртэй төстэй эдлэлүүд | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 4,256 | 256 | 0 | 6% |
| 94054080 | Өнгөт метаалаас өөр материалаар хийсэн цахилгаан чийдэн болон гэрэлтүүлэх хэрэгслүүд, несой байдлаар | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 26,761 | 0 | 3.9% |
| 94060080 | Угсармал байшин, модон бус | Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаагүй байгаа | 0 | 0 | 2,510 | 2.9% |
| **НИЙТ** | | | **452,647** | **212,672** | **382,319** | |

**ХЕС-д хамрагдах боломж бүхий сүлжмэл, бөс даавуун бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх (бүрэн хэмжээний жагсаалтыг хавсралт А-гаас үзнэ үү)**

*ХЕС-д хамрагдах боломж бүхий сүлжмэл, бөс даавуун бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх: ноолуур*

- ☐ 51031000: Ноос буюу амьтны сайн чанарын үсний сэв (0.4%)
- ☐ 51032000: Ноос буюу амьтны сайн чанарын үсний бусад төрлийн хаягдал (1 кг-ын үнэ нь 2.6 цент)
- ☐ 57025120: Шалны дэвсгэр (гар аргаар нэхсэн, бөөгнөрүүлээгүй) (4.3%)
- ☐ 57031020: Гар аргаар нэхсэн, цацаг бүхий хивс болон ноос, эсвэл амьтны сайн чанарын үсээр урласан бусад төрлийн шалны дэвсгэр (6%)
- ☐ 51161008: Спортын бээлий, хуруутай болон хуруугүй бээлий (2.8%)

- ☐ 63049940: Ноос буюу амьтны сайн чанарын үсээр гар аргаар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн хананд өлгөх зориулалттай эд зүйлс
- ☐ 63049910: Ноос буюу амьтны сайн чанарын үсээр гар аргаар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн дэрний уут
- ☐ 65069900: Резин, хуванцар, эсвэл амьтны арьснаас бусад төрлийн материалаар хийсэн, хуниастай, эсвэл хуниасгүй, эмжээрлэсэн, эсвэл үгүй байдалтай малгай

*ХЕС-д хамрагдах боломж бүхий сүлжмэл, бөс даавуун бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх: арьс шир*

- ☐ 65010060: Эмэгтэйчүүд, охидын малгайны арьсаар хийсэн хэв загвар, гаднахь их бие, юүдэн
- ☐ 65069200: Амьтны арьсаар хийсэн, хуниастай, эсвэл хуниасгүй, эмжээрлэсэн, эсвэл үгүй байдалтай малгай

*АНУТУС-д заасан бараа бүтээгдэхүүний тодорхойлолт ёсоор эдгээр бүтээгдэхүүн нь 70 буюу түүнээс дээш хувийн агуулгатай торго, эсвэл хаягдал торгоноос бүрдэх ёстой бөгөөд энэ утгаараа техникийн хувьд 30 буюу түүнээс доош хувийн агуулгатай ноолууртай хольсон байж болох юм:*

- ☐ 61171040 Ердийн буюу дэгээ зүүгээр нэхсэн, жингийнх нь 70 буюу түүнээс дээш хувь нь торго, эсвэл хаягдал торгоноос бүтсэн нөмөрдөг алчуур, ороолт гэх зэрэг эдлэл
- ☐ 61178085 Жингийнх нь 70 буюу түүнээс дээш хувь нь ердийн, эсвэл дэгээ зүүгээр нэхсэн торго агуулснаас бусад төрлийн сүлжмэл материалаар хийсэн үс дарах зориулалттай, толгойд уядаг тууз, үсний даруулга, хавчаар буюу эдгээртэй төстэй эдлэлүүд
- ☐ 62131010 Ердийн буюу дэгээ зүүгээр нэхээгүй, жингийнх нь 70 буюу түүнээс дээш хувь нь торго, эсвэл хаягдал торгоноос бүтсэн халаасны алчуур
- ☐ 62141010 Ердийн буюу дэгээ зүүгээр нэхээгүй, жингийнх нь 70 буюу түүнээс дээш хувь нь торго, эсвэл хаягдал торгоноос бүтсэн нөмөрдөг алчуур, ороолт, хүзүүний ороолт, нүүрний хаалт, гивлүүр болон эдгээртэй төстэй бусад эдлэлүүд
- ☐ 62171085 Жингийнх нь 70 буюу түүнээс доош хувь нь торго, эсвэл хаягдал торго бүхий материалаас өөр төрлийн даавуугаар ердийн буюу дэгээ зүүгээр нэхсэн үс дарж боох зориулалттай боолт, гэзэгний даруулга, хавчаар буюу эдгэртэй төстэй бусад эдлэлүүд
- ☐ 62043960 Ердийн буюу дэгээ зүүгээр нэхээгүй, жингийнх нь 70 буюу түүнээс дээш хувь нь торго, эсвэл хаягдал торгоноос бүтсэн, эмэгтэйчүүд ба охидод зориулсан костюм хэлбэрийн хүрэм ба спортын хүрэм
- ☐ 62044910 Ердийн буюу дэгээ зүүгээр нэхээгүй, жингийнх нь 70 буюу түүнээс дээш хувь нь торго, эсвэл хаягдал торгоноос бүтсэн, эмэгтэйчүүд ба охидын даашинз

**Аж үйлдвэрийн зарим нэр төрлийн барааг ХЕС-ийн дагуу гаалийн татваргүйгээр АНУ руу экспортлох боломжийг эрэлхийлэх**

- ☐ Зэсийн хүдэр, баяжмал, исэл, сульфат болон зэсээр хийсэн бүтээгдэхүүн
- ☐ Вольфрамын баяжмал, исэл болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнүүд
- ☐ Цинк ба вольфрам голдуу агуулсан үнс чандруу буюу тэдгээрийн үлдэгдэл
- ☐ Өндөр температурт гарган авсан нүүрсний давирхайн нэрмэл

- ☐ Молибдений исэл, хиймийн нэгдлүүд, гулдмай, савх төмөр, утас, лист болон хавтан
- ☐ Цагаан тугалганы нэгдлүүд, хайлш, бусад олон төрлийн бүтээгдэхүүн
- ☐ Алтны нэгдлүүд болон алтаар урласан эрдэнийн чулуун гоёл чимэглэлийн зүйлс

**Монгол Улсад үйлдвэрлэгдсэн, ХЕС-д хамрагдах боломжтой, өрсөлдөх чадвар сайтай бараа бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээл рүү экспортлох**

- ☐ Үхэр, адууны шир
- ☐ Зэсийн хүдэр ба баяжсал
- ☐ Хагас боловсруулсан алт
- ☐ Бусад төрлийн ашигт малтмал (өмнөх хэсгээс холбогдох мэдээллийг үзнэ үү)
- ☐ Лаазалсан мах болон төрөл бүрийн үүлдрийн үхрийн цувдай
- ☐ Үхэр, адууны түүхий арьс, шир
- ☐ Самнаагүй ноос
- ☐ "Хүнс, ундаа ба тамхи"

**Монгол Улсаас дэлхий дахин, ЕХ болон Япон руу гаргаж буй импортод тулгуурлан ХЕС-ийн дагуу Монгол Улсаас АНУ-ын авч болох импортын бараа бүтээгдэхүүн**

ЕХ болон Япон руу нэлээн их хэмжээгээр (жилд хамгийн багадаа дунджаар 10,000 америк долларын өртөгтэй байх), мөн Монгол Улсаас дэлхийн дахинд харьцангүй их хэмжээгээр буюу 50000 америк доллараас дээш үнэлгээтэйг гаргасан боловч 2003-2005 оны хооронд АНУ руу маш бага хэмжээгээр импортлогдсон, эсвэл бүр огт гараагүй бөгөөд ХЕС-д хамрагдах боломжтой бараа бүтээгдэхүүний нэр төрлүүд байна. (Дорх хүснэгтийг үзнэ үү.) Эдгээр нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд шөл, махтай шөл, цахиур, зарим нэр төрлийн цэвэрлэгч бодис, стеариний хүчил, зарим төрлийн хуванцар (метакрилатийн полиметил, терефталатийн полиэтилен болон төрөл бүрийн хуванцар бүтээгдэхүүн), шир, үслэг арьс, модоор урласан бүтээгдэхүүн (хаалга, ширээний хэрэгсэл, гал тогооны хэрэгсэл болон модоор хийсэн бусад эд зүйлс), ноосны буюу амьтны сайн чанарын үсний хаягдал хог, нийлэг мяндасан бээлийний зарим нэр төрөл, тавилганы сүлжмэл тоног хэрэгслүүд, нэг удаагийн улавч шаахай, дуриамал чулуун гоёл чимэглэлийн зүйлс, төмрийн хайлш, крант, салхины хэмжүүр, хавхлаг болон аккумулятор тус тус багтана.

ЗХ-ийн зөвхөн 3 буюу түүнээс өндөр хувьтай AVE дундаж тарифтай 6 оронтой хэсгүүдийг жагсаалтад багтаасан гэдгийг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн ЗХ-ийн 6 оронтой зарим хэсгүүд, тухайлбал нийлэг мяндасан бээлий, тавилганы сүлжмэл тоног хэрэгслүүд болон хөлд угладаг эдлэлүүдийг багтаасан хэсгүүдэд ХЕС-д хамрагдахгүй байж болох, АНУ-ын дотоодын үйлдвэрлэгчдэд ихээхэн сөргөөр нөлөөлж болохуйц нэр төрлийн бараа бүтээглдэхүүнийг агуулж байж болзошгүй юм.

**Хүснэгт –АНУ-ын бага хэмжээгээр авдаг импортын бараа бүтээгдэхүүнийг 2003-2005 оны хооронд дэлхий дахин, ЕХ болон Япон руу импортолсон байдал**

| УС 6 оронтой | 6 оронтой УС-ийн тодорхойлолт | 6 оронтой УС Дундаж | ХЕС-ийн 8 оронтой тооллын "А" 6 оронтой УС дэх АНУТУС-ийн | Монгол Улсаас **дэлхийн улс орнууд руу** гаргасан импорт, | Монгол Улсаас **Европын холбооны улсууд руу** гаргасан импорт, | Монгол Улсаас **Япон руу** гаргасан импорт, 2003-05 оны дунджаар, | Монгол Улсаас **АНУ руу** гаргасан импорт, 2003-05 оны дунджаар, |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | мөрүүд | 2003-05 оны дунджаар, ам. доллараар | 2003-05 оны дунджаар, ам. доллараар | ам. доллараар | ам. доллараар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 210410 | Шөл, махтай шөл, тэдгээрийн бэлдмэлүүд | 3.2% | 3-аас 3 | 69,687 | 0 | 0 | 0 |
| 280469 | Жингийнх нь 99.99%-иас бага хэсэг нь цахиураас бүрдэх цахиур материал | 5.4% | 6-аас 3 | 114,239 | 0 | 0 | 0 |
| 340211 | Гадаргууг идэвхтэй цэвэрлэх, анионий, органик бодисны найрлагатай уусмал (саван бус) | 4.7% | 9-өөс 9 | 12,094 | 12,094 | 0 | 0 |
| 382311 | Стеариний хүчил (саван, лаа, гоо сайхны бүтээгдэхүүн, тосон будаг зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүний найрлагад ордог) | 7.0% | 3-аас 3 | 18,118 | 18,118 | 0 | 0 |
| 390610 | Метакрилатийн полиметил, анхдагч байдлаараа (шил орлуулагч) | 6.3% | 3-аас 3 | 13,806 | 13,806 | 0 | 0 |
| 390760 | Терефталатийн полиэтилен, анхдагч байдлаараа (Хүний гараар бүтсэн мяндасны гол түүхий эд болдог) | 6.5% | 3-аас3 | 23,257 | 0 | 21,447 | 0 |
| 392690 | Төрөл бүрийн хуванцар бүтээгдэхүүн | 4.3% | 71-ээс 54 | 24,708 | 10,358 | 0 | 6,028 |
| 410791 | Үхэр, адууны том ширхэгтэй хуваагаагүй ширний зарим төрөл | 3.2% | 15-аас 15 | 21,158 | 18,324 | 0 | 0 |
| 430230 | Идээлүүлсэн, элдсэн үслэг арьс (бүхлээрээ, хэсэглэсэн, эсвэл хэрчсэн) | 5.3% | 3-аас 3 | 18,438 | 17,760 | 678 | 0 |
| 441820 | Модон хаалга, хүрээ болон босго | 4.8% | 6-аас 6 | 12,601 | 12,601 | 0 | 0 |
| 441900 | Модоор урласан ширээний болон гал тогооны хэрэгсэл | 4.3% | 6-аас 6 | 955,083 | 0 | 0 | 942 |
| 442190 | Модон хаалт, хаагч, халхавч, сүүдрэвч; ээрүүл, чихрийн буюу зайрмагны модон иш, хэлэн дээр дарагч багаж, ундааны зүйлийг хологч \шүдний чигчлүүрээс бусад\ | 3.1% | 27-оос 9 | 38,682 | 34,081 | 0 | 0 |
| 510320 | Ноос буюу амьтны сайн чанарын үсний сэв, хаягдал | 3.0% | 3-аас 3 | 69,606 | 26,372 | 13,223 | 0 |
| 611693 | Ердийн, эсвэл дэгээ зүүгээр нэхсэн нийлэг мяндасан бээлий, хуруутай буюу хуруугүй бээлий | 9.7% | 16-аас 3 | 69,120 | 333 | 0 | 0 |
| 630499 | Ердийн, эсвэл дэгээ зүүгээр нэхээгүй, сүлжмэл материалаар хийсэн ханан дээр өлгөх зориулалттай аравч болон дэрний уут | 7.5% | 18-аас 9 | 52,067 | 48,364 | 0 | 3,703 |
| 640590 | Нэг удаагийн углааш, шаахай | 8.2% | 6-аас 3 | 58,613 | 48,209 | 0 | 0 |
| 711790 | Шашны холбогдолтой эрдэнийн чулуун буюу төрөл бүрийн дууриамал чулуун эдлэл (өнгөт металл бус) | 3.2% | 16-аас 12 | 32,205 | 32,193 | 0 | 0 |
| 720299 | Төрөл бүрийн агуулгатай төмрийн хайлш (Ган, хайлш үйлдвэрлэхэд түүхий эд болдог) | 4.7% | 9-өөс 6 | 62,726 | 16,332 | 0 | 0 |
| 848180 | Хоолой, торхны цорго\гоожуур, салхины хэмжүүр, хавхлаг \термостатаар удирдагддаг хавхлаг үүнд багтана\ | 3.7% | 12-оос 12 | 27,599 | 16,000 | 0 | 0 |
| 850780 | Төрөл бүрийн аккумулятор | 3.4% | 6-аас 6 | 10,422 | 10,333 | 0 | 0 |

